

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/50/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ГАЛСҮРЭН
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/50/НА-СТА-ТшЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200549

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,956,670.67	109,255,683.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,678.00	1,678.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,678.00	1,678.00
31110	Төгрөг	1,678.00	1,678.00
33	АВЛАГА	1,620,696.38	298,439.33
335	Бусад авлага	1,620,696.38	298,439.33
3351	Байгууллагаас авах авлага	634,999.38	298,439.33
3352	Хувь хүмүүсээс авах авлага	985,697.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,334,296.29	108,955,566.29
354	Хангамжийн материал	85,334,296.29	108,955,566.29
35410	Бичиг хэргийн материал	1,392,102.50	26,383,472.50
35420	Аж ахуйн материал	6,420,600.00	6,420,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	799,800.00	799,800.00
35470	Бусад хангамжийн материал	76,721,793.79	75,351,693.79
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	455,401,038.42	455,542,645.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	455,401,038.42	455,542,645.78
392	Биет хөрөнгө	412,835,038.42	412,976,645.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	117,216,941.53	117,216,941.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,125,710.63	-33,173,432.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,990,000.00	98,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,987,240.65	-59,471,279.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	195,821,090.62	246,394,650.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,848,495.46	-32,621,511.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,772,676.50	90,772,676.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,539,444.52	-22,008,331.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,671,400.00	8,671,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-136,178.97	-1,794,468.90
393	Биет бус хөрөнгө	42,566,000.00	42,566,000.00
39301	Програм хангамж	480,000.00	480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,000.00	-480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,566,000.00	42,566,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН ш=т+п	542,357,709.09	564,798,329.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	542,357,709.09	564,798,329.40
51	Засгийн газрын хувь оролцоо	542,357,709.09	564,798,329.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,245,746.77	249,245,746.77
51101	Өмч: - төрийн	249,245,746.77	249,245,746.77
512	Хуримтлагдсан үр дүн	200,923,215.35	223,363,835.66
51210	Өмнөх үеийн үр дүн	-75,811,415.94	200,288,215.97
51220	Тайлант үеийн үр дүн	276,734,631.29	23,075,619.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,188,746.97	92,188,746.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН ҮМҮ+Ү	542,357,709.09	564,798,329.40

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,530,880.73	1,151,657,240.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,847,380.73	65,309,429.99
120	Нийтлэг татварын бус орлого	201,847,380.73	65,309,429.99
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,370,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,370,000.00	0.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	199,477,380.73	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөр		43,506,359.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа мат		21,803,070.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	969,683,500.00	1,086,347,811.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	969,683,500.00	1,086,347,811.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	969,683,500.00	1,086,347,811.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
133003	Хөрөнгийн	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,796,249.44	1,128,581,621.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,796,249.44	1,128,581,621.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,217,188.35	1,040,733,167.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,400,545.62	734,690,843.92
210101	Үндсэн цалин	416,063,035.62	418,767,510.62
210102	Нэмэгдэл	128,058,799.00	145,013,860.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,913,366.00	58,518,550.91
210104	Урамшуулал	65,365,345.00	112,390,922.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	78,764,400.00	99,305,860.67
210201	Тэтгэврийн даатгал	53,305,500.00	83,149,751.47
210202	Тэтгэмжийн даатгал	6,364,700.00	4,373,343.45
210203	ҮОМШ өвчний даатгал	5,091,800.00	3,407,954.75
210204	Ажилгүйдлын даатгал	1,272,900.00	761,346.54
210205	Эрүүл мэндийн даатгал	12,729,500.00	7,613,464.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,775,714.91	39,619,021.55
210301	Гэрэл цахилгаан	2,849,971.91	3,623,617.55
210302	Түлш, халаалт	21,107,625.00	33,728,404.00
210303	Цэвэр, бохир ус	818,118.00	2,267,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,659,981.00	35,189,500.00
210401	Бичиг хэрэг	5,194,800.00	7,041,339.22
210402	Тээвэр, шатахуун	8,583,000.00	6,911,100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,117,699.00	6,697,910.78
210404	Ном, хэвлэл	149,200.00	333,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	671,800.00	1,071,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,943,482.00	13,134,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,220,000.00	5,800,000.00
210604	Урсгал засвар	4,220,000.00	5,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,555,600.00	6,512,000.00
210702	Дотоод албан томилолт	6,555,600.00	6,512,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,184,198.00	60,631,988.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,411,390.00	54,458,405.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,208.00	123,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	5,000,000.00

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,656,748.82	58,983,952.63
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	10,497,900.00	8,552,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	39,158,848.82	50,431,952.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,579,061.09	87,848,453.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,230,000.00	75,732,510.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,230,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	0.00	75,732,510.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,349,061.09	12,115,943.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,349,061.09	12,115,943.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	276,734,631.29	23,075,619.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	276,734,631.29	23,075,619.69

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	972,053,500.00	1,086,962,926.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	972,053,500.00	1,086,962,926.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	969,683,500.00	1,086,347,811.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	969,683,500.00	1,086,347,811.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,370,000.00	615,115.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	730,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	615,115.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	887,859,500.00	1,079,895,726.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,859,500.00	1,079,895,726.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,280,438.91	991,432,157.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,406,127.00	733,705,146.92
210101	Үндсэн цалин	417,068,617.00	417,781,813.62
210102	Нэмэгдэл	128,058,799.00	145,013,860.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,913,366.00	58,518,550.91
210104	Урамшуулал	65,365,345.00	112,390,922.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,764,400.00	99,604,300.00
210201	Тэтгэврийн даатгал	78,764,400.00	83,448,190.80
210202	Тэтгэмжийн даатгал	0	4,373,343.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	3,407,954.75
210204	Ажилгүйдлийн даатгал	0	761,346.54
210205	Эрүүл мэндийн даатгал	0	7,613,464.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,775,714.91	39,619,021.55
210301	Гэрэл, цахилгаан	2,849,971.91	3,623,617.55
210302	Түлш, халаалт	21,107,625.00	33,728,404.00
210303	Цэвэр, бохир ус	818,118.00	2,267,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,864,399.00	35,226,900.00
210401	Бичиг хэрэг	5,427,300.00	7,057,639.22

210402	Тээвэр, шатахуун	8,583,000.00	6,911,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,117,699.00	6,697,910.78
210404	Ном, хэвлэл	447,600.00	333,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	671,800.00	1,071,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,617,000.00	13,155,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,220,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	4,220,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,555,600.00	6,512,000.00
210702	Дотоод албан томилолт	6,555,600.00	6,512,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,184,198.00	67,364,788.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,411,390.00	61,191,205.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,208.00	123,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	5,000,000.00
210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,510,000.00	8,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,766,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,744,000.00	8,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,579,061.09	88,463,568.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,230,000.00	75,732,510.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	75,732,510.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	730,000.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,349,061.09	12,731,058.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,349,061.09	12,115,943.99
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	615,115.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	84,194,000.00	7,067,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	84,194,000.00	7,067,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	84,194,000.00	7,067,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	84,194,000.00	7,067,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	84,194,000.00	7,067,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-84,194,000.00	-7,067,200.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,678.00	1,678.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,678.00	1,678.00
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0	0

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97.00	-75,811,415.94	265,623,077.80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	-75,811,415.94	265,623,077.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	276,734,631.29	276,734,631.29
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	200,923,215.35	542,357,709.09
D01	2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	200,923,215.35	542,357,709.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-634,999.38	-634,999.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	200,923,215.35	541,722,709.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,075,619.69	23,075,619.69
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	223,363,835.66	564,798,329.40

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,678.00	-1,678.00	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,086,347,900.00	1,074,231,867.01	12,116,032.99	98.88
УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,347,900.00	1,074,231,867.01	12,116,032.99	98.88
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,615,300.00	998,499,357.01	12,115,942.99	98.80
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	739,550,100.00	733,705,146.92	5,844,953.08	99.21
Үндсэн цалин	427,379,500.00	417,781,813.62	9,597,686.38	97.75
Нэмэгдэл	127,561,500.00	145,013,860.29	-17,452,360.29	113.68
Унаа хоолны Хөнгөлөлт	68,244,000.00	58,518,550.91	9,725,449.09	85.75
Урамшуулал	116,365,100.00	112,390,922.10	3,974,177.90	96.58
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,604,300.00	99,604,300.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	70,022,300.00	83,448,190.80	-13,425,890.80	119.17

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тэтгэмжийн даатгал	7,395,500.00	4,373,343.45	3,022,156.55	59.14
ҮОМШӨ-ний даатгал	5,916,400.00	3,407,954.75	2,508,445.25	57.60
Ажилгүйдлийн даатгал	1,479,100.00	761,346.54	717,753.46	51.47
Эрүүл мэндийн даатгал	14,791,000.00	7,613,464.46	7,177,535.54	51.47
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,989,800.00	39,619,021.55	5,370,778.45	88.06
Гэрэл, цахилгаан	3,839,400.00	3,623,617.55	215,782.45	94.38
Түлш, халаалт	37,783,400.00	33,728,404.00	4,054,996.00	89.27
Цэвэр, бохир ус	3,367,000.00	2,267,000.00	1,100,000.00	67.33
Хангамж, бараа материалын зардал	35,226,900.00	35,226,900.00	0.00	100.00
Бичиг хэрэг	6,560,000.00	7,057,639.22	-497,639.22	107.59
Тээвэр, шатахуун	6,672,000.00	6,911,100.00	-239,100.00	103.58
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,740,500.00	6,697,910.78	2,042,589.22	76.63
Ном, хэвлэл	433,400.00	333,800.00	99,600.00	77.02
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,071,000.00	1,071,000.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,750,000.00	13,155,450.00	-1,405,450.00	111.96
Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	5,800,000.00	0.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
Урсгал засвар	800,000.00	800,000.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	6,692,000.00	6,512,000.00	180,000.00	97.31
Дотоод албан томилолт	6,692,000.00	6,512,000.00	180,000.00	97.31
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,432,200.00	69,431,988.54	211.46	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,258,500.00	63,258,405.54	94.46	100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	170,800.00	170,775.00	25.00	99.99
Тээврийн хэрэгслийн татвар	123,300.00	123,208.00	92.00	99.93
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
Газрын төлбөр	425,600.00	425,600.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	9,320,000.00	8,600,000.00	720,000.00	92.27
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	9,320,000.00	8,600,000.00	720,000.00	92.27
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,732,600.00	75,732,510.00	90.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	75,732,600.00	75,732,510.00	90.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,732,600.00	75,732,510.00	90.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,086,347,900.00	1,074,231,867.01	0.00	100.06
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,086,347,900.00	1,074,231,867.01	0.00	100.06
Улсын төсвөөс санхүүжих	1,086,347,900.00	1,074,231,867.01	0.00	100.06
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,678.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,678.00	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Татварын хэлтсийн нь нутаг дэвсгэрийн хэмжээнд татварын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар, төлбөр хураамж, татварын оногдуулалт тайлагналын талаар иргэд, ААНБ-ыг мэдээллээр ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,158.3 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,129,196.7 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 5,645.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,516.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 542,696.8 мянган төгрөг буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.6	1.6	0.0
Авлага	1,620.6	298.4	-1,322.2
Бараа материал	85,334.3	108,955.5	23,621.2
Үндсэн хөрөнгө	455,401.0	455,542.6	141.6
Нийт хөрөнгө	542,357.7	564,798.3	22,440.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	542,357.7	564,798.3	22,440.6

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	542,357.7	564,798.3	22,440.6
---	-----------	-----------	----------

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс 1.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага данс оны эхэнд 1,620.0 мянган төгрөгөөс 298.0 мянган төгрөг болж буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 108,955.5 мянган төгрөг болж 23,621.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бичиг хэргийн материал болон ТЕГ-аас үнэ төлбөргүй ирсэн бараа материал зарцуулагдаагүй үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Нийт хөрөнгийн данс 564,798.3 мянган төгрөг болж 22,440.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ТЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 564,798.3 мянган төгрөг болж 22,440.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,152,272.3 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1,129,854.1 мянган төгрөг буюу 26.1 хувиар өссөн байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хангамж бараа материал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Татварын хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 936,590.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 936,590.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 75,732.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,086,347.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь оны эцэст тэтгэвэрт гарахад нэг удаа олгох мөнгөн тэтгэмжийн зардал нэмж олгосонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,086,347.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,086,347.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,086,347.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,074,231.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,074,231.0 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 615.0 мянган төгрөг сангийн яамнаас орж ирж буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Татварын хэлтсийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцроосон 5, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа зөв ангилж тусгаж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 7,067.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 7,067.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчин 7,067.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдааг залрууллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Увс аймгийн Татварын хэлтсийн	1	7,067.2	1	7,067.2						
	ДҮН	1	7,067.2	1	7,067.2						

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 19-ний өдөр